

ГЕРМЕСЦЕНТР
ХК

ТТБ1437-2773678

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	"Гермес Центр"ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн төв оффисын байр, холбогдох утас: 30-15-77, 99 08 85 71
Хурал хуралдах өдөр, цаг:	2021 оны 04-р сарын 09-ний өдрийн 15 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/ :	Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, "Гермес Центр"ХК-ийн оффисын байрны 3-р давхарт байрлах хурлын танхимд хосолсон хэлбэрээр
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдуулах шийдвэр гаргасан огноо:	2021 оны 02-р сарын 17-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2021 оны 02-р сарын 22-ны өдөр, 2021 оны 03-р сарын 10-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2021 оны 03-р сарын 11-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо:	2021 оны 02-р сарын 22-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2021 оны 02-р сарын 19-ний өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссын дарга О.Энхжаргал гишүүд Г.Батзориг, Л.Оюунгэрэл
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолууд, бусад хавсралтуудын хамт
Баримт, бичгийн хуудасны тоо:ширхэг
хуудас



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

...../Д.Эрдэнэсүрэн /

2021 оны 02-р сарын 19-ний өдөр

ТТБ1437-2773678



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

**Санхүүгийн
тайланг батлах тухай**

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлын шийдвэр болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр” ХК-ийн 2020 оны сүүлийн хагас жилийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



[Signature]
Д.ОЮУНСҮРЭН



“ЦЭСБ-АУДИТ” ХХК

УБ дахь оффис: Хан-Уул дүүрэг 20-р хороо, Мишээл хотхон
94-А байрны 01-р давхар, Зтоот; Утас: 99099605, 99019203;
Шуудангийн хаяг: erkaa0315@yahoo.com

2021 / 01 / 19 № 212 / 03

“ ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН УДИРДЛАГАД ”

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “ Гермес центр ” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа “Аудиторын үүрэг хариуцлага” гэсэн хэсэгт харуулсан. Бид энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ажиллаж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж бид үзэж байна.

Бусад мэдээлэл

Компанийн татварын тайлан, газар эзэмших эрхтэй холбоотой бүртгэл, мэдээлэл нь бидэнд хамааралгүй болно. Энэ талаар бид өөрсдийн үзэл баримтлалаа илэрхийлж байсан болно. Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээлэлд хамааралгүй болно.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор компанийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтын талаарх хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайлан гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан боддох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан ба алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлан дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг тодорхойлохын тулд, санхүүгийн тайлангуудыг байгууллага бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт толилуулгыг үнэлдэг.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД

" ГЕРМЕС ЦЕНТР" ХК

Аж ахуйн нэгжийн нэр

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2019.12.31	2020.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах	1	1,771,526,972.31	2,023,254,899.94
Дансны авлага		-	-
Татвар, НДШ-ийн авлага	2	-	-
Бусад авлага		93,389,622.95	83,389,625.95
Бараа материал	3	9,284,594.65	8,151,831.00
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,874,201,189.91	2,114,796,356.89
Үндсэн хөрөнгө		4,238,858,400.69	4,077,359,327.44
Биет бус хөрөнгө	4	2,288,496,000.00	2,288,496,000.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		6,527,354,400.69	6,365,855,327.44
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		8,401,555,590.60	8,480,651,684.33
Дансны өглөг		-	-
Татварын өр		30,571,484.90	68,310,317.00
НДШ-ийн өглөг	5	-	-
Урьдчилж орсон орлого		4,682,937.35	3,977,574.27
Бусад богино хугацаат өр төлбөр		171,405,674.55	173,654,655.22
Богино хугацаат өглөгийн дүн		206,660,096.80	245,942,546.49
Урт хугацаат өр төлбөр		-	-
Нийт өр төлбөрийн дүн		206,660,096.80	245,942,546.49
Эзэмшигчийн өмч			
Хувьцаат /өмч/		7,854,300,100.00	7,854,300,100.00
Эздийн өмчийн бусад хэсэг	6	-	-
Хуримтлагдсан ашиг(алдагдал)		340,595,393.80	380,409,037.84
Эздийн өмчийн дүн		8,194,895,493.80	8,234,709,137.84
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		8,401,555,590.60	8,480,651,684.33

Хавсаргаасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН
БАЙГУУЛЛАГА-2
"ЦЭСБ-АУДИТ" ХХК

" ГЕРМЕС ЦЕНТР" ХК

Аж ахуйн нэгжийн нэр

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2019.12.31	2020.12.31
Борлуулалтын орлого	7	1,449,256,652.85	1,540,194,398.62
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг /алдагдал/		1,449,256,652.85	1,540,194,398.62
Хүүний орлого	8	202,988,591.38	206,523,085.80
Бусад орлого		287,000.00	154,000.00
Борлуулалт маркетингийн зардал			-
Ерөнхий ба удирдлагын зардал	9	735,860,450.50	735,056,672.04
Санхүүгийн зардал			-
Бусад зардал		5,000,790.00	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	10	6,438.53	2,749.17
Бусад ашиг (алдагдал)			-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		911,677,442.26	1,011,817,561.55
Орлогын татварын зардал	11	91,667,181.10	101,181,481.24
Татварын дараах ашиг (алдагдал)		820,010,261.16	910,636,080.31
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг			-
Тайлант үеийн цэвэр ашиг		820,010,261.16	910,636,080.31
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Орлогын нийт дүн		820,010,261.16	910,636,080.31
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		10.44	11.59

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН
БАЙГУУЛЛАГА-2
"ЦЭСЬ-АУДИТ" ХХК

" ГЕРМЕС ЦЕНТР" ХК

Аж ахуйн нэгжийн нэр

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	7,854,300,100.00	330,702,865.81	8,185,002,965.81
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	1,925,961.77	1,925,961.77
Залруулсан үлдэгдэл	7,854,300,100.00	332,628,827.58	8,186,928,927.58
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		820,010,261.16	820,010,261.16
Зарласан ногдол ашиг		812,043,694.94	812,043,694.94
2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	7,854,300,100.00	340,595,393.80	8,194,895,493.80
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	7,854,300,100.00	340,595,393.80	8,194,895,493.80
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	910,636,080.31	910,636,080.31
Зарласан ногдол ашиг		870,822,436.27	870,822,436.27
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	7,854,300,100.00	380,409,037.84	8,234,709,137.84

" ГЕРМЕС ЦЕНТР" ХК

Аж ахуйн нээжийн нэр

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ны өдрөөрх

Мөр №	Өмч	2019.12.31	2020.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,095,265,317.57	2,202,831,297.83
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,568,411,018.68	1,669,321,357.53
	Бусад мөнгөн орлого	526,854,298.89	533,509,940.30
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,453,736,734.23	1,378,835,999.29
	Ажиллагчдад төлсөн	222,676,400.00	271,550,410.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	62,192,454.00	30,457,129.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	28,701,130.00	23,592,795.00
	Ашиглалтын зардалд төлсөн	142,691,548.80	142,118,810.34
	Түлш, шатахуун, т/хөлс, сэлбэг/х-д төлсөн	946,137.00	515,100.00
	Татварын байгууллагад төлсөн	361,310,650.54	311,418,446.19
	Бусад мөнгөн зарлага	635,218,413.89	599,183,307.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн мөнгөн гүйлгээний дүн	641,528,583.34	823,995,298.54
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	202,988,591.38	206,523,085.80
	Хүлээн авсан хүүгийн орлого	202,988,591.38	206,523,085.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,857,260.01	2,141,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	12,857,260.01	2,141,000.00
2.3	ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	190,131,331.37	204,382,085.80
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	293,438.53	156,749.17
	Бусад орлого	293,438.53	156,749.17
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	671,542,658.55	776,806,205.88
	Төлсөн ногдол ашиг	671,542,658.55	776,806,205.88
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(671,249,220.02)	(776,649,456.71)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	160,410,694.69	251,727,927.63
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,611,116,277.62	1,771,526,972.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,771,526,972.31	2,023,254,899.94



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20²¹ оны ⁰² сарын ¹⁷ өдөр

Дугаар: ⁰²

Улаанбаатар хот

Цэвэр ашгийг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6-р бүлгийн 46-р зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. "Гермес центр" ХК-ийн 2020 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг 380.4 сая төгрөгийн
 - 99.17 %-ийг буюу 377 006 404.8 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар
 - 0.83 %-ийг буюу 3 402 633.04 төгрөгийг компанийн цалин урамшуулал болон нөөцийн санд тус тус хуваарилсугай.
2. "Гермес центр" ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тарааж олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



 Д.ОЮУНСҮРЭН



**ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20... 21 оны 02 сарын 17 өдөр

Дугаар: 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг
хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46-р зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2020 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас хуваарилагдсан нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээг 4 төгрөг 80 мөнгө /дөрвөн төгрөг наян мөн/-өөр тогтоосугай.
2. “Гермес центр” ХК-ийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 03-р сарын 11-ний өдрөөр тасалбар болгосугай.
3. “Гермес центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2021 оны 03-р сарын 15-ны өдрөөс эхлэн олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/ нарт даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.ОЮУНСҮРЭН



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар: 05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилах журам”-ыг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/, нягтлан бодогч /О.Энхтуяа/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэсүрэн/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.





“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ
ХУВААРИЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар (цаашид Журам гэх) Гермес Центр ХК (цаашид Компани гэх)-ийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон бусад зохицуулах байгууллагаас гаргасан дүрэм, журмуудад нийцсэн байх ба Компанийн ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаанд тэдгээрийг мөрдлөг болгоно.
- 1.3 Энэхүү журмыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) баталснаар хүчин төгөлдөр хэрэгжинэ.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

- 2.1 Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хуваарилах бодлого баримтална.
- 2.2 Компанийн хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурьдсан нөхцөлд татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.
 - 2.2.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
 - 2.2.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүний татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх
 - 2.2.3 Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа авсан байх
- 2.3 Компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргаж, энэ тухай хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлнэ. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэрлэсэн байна.
- 2.4 ТУЗ-өөс тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргавал энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах үүрэгтэй.
- 2.5 ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарсанаас хойш 30 хоногийн дотор гаргах ба 2.2.1 – 2.2.3-т заасан нөхцлүүд хангагдсан байна.
- 2.6 ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заасан байна.
- 2.7 Ногдол ашиг төлөх хэлбэр болон хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байх ба холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зааврыг харгалзана.

ГУРАВ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

3.1 Компанийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн тооцооллыг ТУЗ гаргах бөгөөд Гүйцэтгэх удирдлагын зүгээс санал оруулж болно.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ

4.1 ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжинд нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргуулан авна.

4.2 Компани ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журамд заасан шаардлагыг биелүүлсэн байна.

4.3 ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах болон компанийн ажилтан ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор компанийн цалин урамшуулал, нөөцийн санд тус тус хуваарилах шийдвэр гаргаж болно.

4.4 ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ дараах зүйлийг заавал тусгана. Үүнд:

4.4.1 Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ,

4.4.2 Ногдол ашгийг төлөх хугацаа,

4.4.3 Төлөх арга зам, хэлбэр (Компани өөрөөр болон эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулах, эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар төлөх гэх мэт)

4.4.4 Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

4.4.5 Бусад холбогдох асуудал

4.5 ТУЗ-өөс ногдол ашиг төлөх өдрийг тогтоохдоо компанийн батлагдсан төсөв төлөвлөгөөтэй уялдуулан хугацааг харгалзана.

4.6 Компани өөрийн цахим хуудсанд зарласан ногдол ашгийн хэмжээ, ногдол ашиг хуваарилсан талаарх мэдээлийг тогтмол оруулна.

4.7 Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртлэх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.

4.8 Компанийн цалин урамшуулал нөөцийн санд хуваарилагдсан мөнгийг зарцуулах журмыг Гүйцэтгэх захирал боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

ТАВ. ТАЙЛАГНАХ

5.1 Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

5.2 Ногдол ашиг төлсний дараагийн улирлын санхүүгийн тайланд Компани энэ талаар Нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу үнэн зөвөөр тайлагнах үүрэгтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 Ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын хууль, дүрэм, журмыг зөрчвөл буруутай этгээд хариуцлага хүлээнэ.

6.2 Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд компанид учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар: 06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3-р заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:


1. “Гермес Центр” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн 15:00 цагт компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд хосолсон хэлбэрээр хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
 - 2.2 Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
 - 2.3 Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийн тухай
 - 2.4 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
 - 2.5 Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтын тухай
 - 2.6 Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж батлах тухай
 - 2.7 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай
 - 2.8 Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2021 оны 03-р сарын 11-ний өдрөөр тогтоосугай.

4. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2021 оны 02-р сарын 19-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 1-р баталж, 2021 оны 02-р сарын 22 болон 2021 оны 03-р сарын 10-ны өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2021 оны 02-р сарын 22-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын энгийн санал авах саналын хуудсыг хавсралт 3-р, кумулятив аргаар санал авах саналын хуудсыг хавсралт 4-р баталж, саналын хуудсыг цахимаар хүлээн авах сүүлчийн өдрийг 2021 оны 04-р сарын 08-ны өдрийн 18:00 цаг хүртэл хүлээн авахыг тооллогын комисс /О.Энхжаргал/-т үүрэг болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэнг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:	О.Энхжаргал - компанийн ажилтан
Гишүүд:	Г.Батзориг - компанийн ажилтан
	Л.Оюунгэрэл - компанийн ажилтан
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Д.Эрдэнэсүрэн - мэргэжилтэн
Гишүүн:	О.Энхтуяа - нягтлан бодогч
11. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зар мэдээ болон бусад зардлыг компанийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирал /Б.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.
12. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол шийдвэртэй уялдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахыг хурлын дарга /Д.Оюунсүрэн/, хурал зохион байгуулах комисс /Д.Эрдэнэсүрэн/ нарт үүрэг болгосугай.
13. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Д.Туяа/-д үүрэг болгосугай.



 Д.ОЮУНСҮРЭН



ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗАРЛАХ ХЭВЛЭЛИЙН ЭХ

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Гермес центр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн 15:00 цагт тус компанийн оффисын байрны 3 давхарт байрлах хурлын танхимд хосолсон хэлбэрээр болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна. Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахим хэлбэрээр оролцох хүсэлтэй бол хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй холбогдож зааварчилгаа авна уу.

Бүртгэлийн өдрийг 2021 оны 03-р сарын 11-ний өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал :

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
- Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
- Компанийн 2019 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийн тухай
- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж батлах тухай
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай
- Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харьяалагдах брокер, диллерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам-20, “Гермес центр” ХК-ийн төв оффисын байрны 3 давхар № 302 тоот өрөөнд ажлын өдрүүдэд утсаар холбогдон 10:00-17:00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцана уу.

Хурал зохион байгуулах:

Комиссын дарга : Д.Эрдэнэсүрэн, утас 9908-8571, имэйл хаяг: erdenee.0922@yahoo.com

Гишүүн : О.Энхтуяа, утас 9909-4991, имэйл хаяг: enkhee_7777@yahoo.com

Зар түгээх мэдээллийн хэрэгслүүдийн жагсаалт:

- Өдрийн сонин
- UBS телевиз
- Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас
- Өөрийн цахим хуудас

Зар гаргах өдрүүд : 2021 оны 02-р сарын 22-ны өдөр, 2021 оны 03-р сарын 10-ны өдөр

Жич : Сонинд зарыг гаргахдаа аудитын дүгнэлт болон санхүүгийн хураангуй тайланг хавсаргана.



“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЦЛАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал

- 1.1 Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт
- 1.2 Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
- 1.3 Компанийн 2019 оны ногдол ашиг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2020 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2021 оны ногдол ашгийн тухай
- 1.4 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай
- 1.5 Компанийн 2021 оны үйл ажиллагааны зорилтын тухай
- 1.6 Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж батлах тухай
- 1.7 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох тухай
- 1.8 Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай



**"ГЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛЫН ХУУДАС**
(Хэлэлцэх асуудал)

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог :

Хувьцаа эзэмшигчийн нэр :

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Брокерийн компанийн нэр :

"Гермес Центр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн 15:00 цагт "Гермес Центр" ХК-ийн төв байранд хосолсон хэлбэрээр болно.

Санал авах хуудас ашиглах санамж

Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ

- 1 нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан эсвэл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.
- 2 Засварласан, балласан болон залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлт			
2	Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт			
3	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай			
4	Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай			

Хувьцаа эзэмшигч (Итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг:/

Санал авах хуудас үйлдсэн 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга:/О.Энхжаргал/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:



ТУЗ-ийн 2021 оны 04-р сарын 17-ны өдрийн
6 тоот тогтоолын хавсралт 4

**"ГЕРМЕС ЦЕНТР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**
(ТУЗ-ийн гишүүдийг сонгох)

Санал хураах арга: Кумулятив

Хувьцаа эзэмшигчийн овог нэр :

Регистрийн дугаар:

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог нэр:

Эзэмшиж буй хувьцааны тоо: Кумулятив саналын тоо:

Брокерийн компанийн нэр :

"Гермес Центр" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн
15:00 цагт "Гермес Центр" ХК-ийн төв байранд хосолсон хэлбэрээр болно.

Тайлбар:

ТУЗ-ийн гишүүн сонгоход таны өгөх нийт саналын эрхийн тоо нь таны эзэмшиж буй энгийн нэг ширхэг хувьцааг компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн 9 гишүүдийн тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл таны санал өгөх эрхийн нийт тоо 100*9 гишүүн=900 ширхэг байна. Та энэхүү 900 саналын эрхээ бүгдийг нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигч эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно. Мөн 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болохоос гадна ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй. Таны сонгогдох гишүүн тус бүрт өгсөн саналын тооны нийлбэр нь таны санал өгөх эрхийн нийт тооноос илүү байж болохгүй. Хэрэв илүү гарсан тохиолдолд саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу. Мөн санал авах хуудсанд засвар оруулсан, балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

№	Нэр дэвшигч	Саналын тоо
ТУЗ-ийн ердийн гишүүдийг улируулан сонгох		
1	Дугаржав овогтой Оюунсүрэн	
2	Батсүх овогтой Оюунцэцэг	
3	Дүвчиндорж овогтой Алтанчимэг	
4	Буянцог овогтой Амарсанаа	
5	Цэенсүрэн овогтой Түвшинжаргал	
6	Намсрай овогтой Мөнхзул	
ТУЗ-ийн хараат бус гишүүдийг улируулан сонгох		
1	Дашцэрэн овогтой Туяа	
2	Нямжав овогтой Батсайхан	
3	Балжинням овогтой Алтангэрэл	

Хувьцаа эзэмшигч (Итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг:/ /

Санал авах хуудас үйлдсэн 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:

Тооллогын комиссын дарга:/О.Энхжаргал/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан: